


**“ЦАХИМ ШИЛЖИЛТИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ЖИЛ”-ИЙН  
ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2024.11.20


Төгрөг сум

№	Ажил, арга хэмжээ	Шаардлагдах хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр	Хугацаа	БИЕЛЭЛТ
<b>1.Удирдлага зохион байгуулалтын талаар</b>				
1.1	“Цахим шилжилтийг эрчимжүүлэх жил”-ийн нээлтийн арга хэмжээг зохион байгуулах	Орон нутгийн төсөв	03 дугаар сар	“Цахим шилжилтийг эрчимжүүлэх жил”-ийн нээлтийн арга хэмжээг сумын төвийн Соёлын төвд 2024 оны 04 дүгээр сарын 15 нд зохион байгуулав. Нийт 96 хүн оролцсон.
1.2	Цахим орчинд хүүхэд хамгаалах чиглэлээр арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулах, эцэг эх, асран хамгаалагч, хүүхдийн оролцоог хангах	Орон нутгийн төсөв	1-4 дүгээр улиралд	Цахим орчны зохистой хэрэглээ сэдвийн хүрээнд 9-12 дугаар ангийн сурагчдад сургалт арга хэмжээ мөн үе тэнгийн дээрэлхэл, цахим хэрэглээ сэдвийн хүрээнд ахлах ангийн сурагчдын дунд “Дэвжээ” тэмцээнийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлтэй хамтран зохион байгуулсан. Тус арга хэмжээнд давхардсан тоогоор 200 гаруй хүүхэд хамрагдсан байна.
1.3	Төрийн байгууллагууд албан хэрэг хөтлөлт, дотоод удирдлагын программ хангамжийг нэвтрүүлэх, албан бичиг солилцооны дундын системд бүрэн холбох, ERP системийг нэвтрүүлэх	Байгууллагын төсөв	1-4 дүгээр улиралд	Төрийн байгууллагууд албан хэрэг хөтлөлт, дотоод удирдлагын программ хангамжийг нэвтрүүлэх, албан бичиг солилцооны дундын системд бүрэн холбох, ERP системийг Засаг даргын Тамгын газар, ргэдийн Төлөөлөгчдийн Хурал нэвтрүүлэн хэрэглэж байна. Бусад төрийн байгууллагууд тухайн системд бүртгүүлэх хүсэлтэй өгсөн.
1.4	Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын мэдээллийн систем, сүлжээний аюулгүй байдлыг хангуулах арга хэмжээ авах (лицензтэй программ хангамж хэрэглэх)	Байгууллагын төсөв	1-4 дүгээр улиралд	Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын мэдээллийн систем, сүлжээний аюулгүй байдлыг хангуулах үүднээс Санхүүгийн 2 лицензтэй программ хангамж хэрэглэдэг.
1.5	Орон нутгийн хэмжээнд төрийн үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр хүртээмжтэй хүргэх боломжийг	Орон нутгийн төсөв	1-4 дүгээр улиралд	“Хурдан” киоск машины үйл ажиллагааг тогтмолжуулах, үйлчилгээ авах иргэдийн тоог нэмэгдүүлэх зорилгоор киоск машиныг

	нэмэгдүүлэх зорилгоор төрийн цахим үйлчилгээний “хурдан” киоск машины үйл ажиллагааг тогтмолжуулах, үйлчилгээ авах иргэдийн тоог нэмэгдүүлэх			нэг цэгийн үйлчилгээний өрөөнд байршуулж үйлчилгээ авч буй иргэдэд сурталчлан таниулж гүйлгээ үзүүлж байна. 
1.6	Сумын ЗДТГ болон төсөвт байгууллагуудын интернэтийн хурдыг нэмэгдүүлэх, сүлжээний өргөтгөл хийх	Байгууллагын төсөв	1-4 дүгээр улиралд	Старлинктэй болж интернэтийн хурдыг нэмэгдүүлэн ,сүлжээний өргөтгөл 100% хийгдсэн.
1.7	Төсөвт байгууллагуудын үйл ажиллагааны талаар иргэдээс сэтгэл хангамжийн судалгааг цахим хэлбэрээр авах, үнэлгээний дүнгээр үйл ажиллагааг эрчимжүүлэх.	Байгууллагын төсөв	Жилдээ	Сургууль, цэцэрлэг цаасаар иргэдээс сэтгэл хангамжийн судалгаа нэг удаа авсан байна.
1.8	Сумын хэмжээнд цахим хэлбэрт шилжсэн төрийн үйлчилгээг иргэд олон нийтэд таниулах, цахимаар үйлчилгээ авах иргэдийн тоог нэмэгдүүлэх	Байгууллагын төсөв	Жилдээ	Нийгмийн даатгал, Татвар, Улсын бүртгэл, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Эрүүл мэндийн төв, Хаан банк, Төрийн банк зэрэг байгууллагууд цахим хэлбэрт шилжсэн үйлчилгээг иргэдэд Багийн хурал болон цахимаар сурталчлан таниулж заавар зөвлөгөө өгч ажиллаж байна. Үйлчилгээний 85% цахим болж, 1075 иргэн цахим үйлчилгээ аваад байна.
1.9	Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (E-Mongolia)-д нэвтрүүлсэн үйлчилгээг	Байгууллагын төсөв	Жилдээ	E-mongolia–г олон нийтэд сурталчлах, иргэдийн авах үйлчилгээг нэмэгдүүлэх

	олон нийтэд сургалчилан таниулах, иргэдийн авах үйлчилгээг нэмэгдүүлэх			зорилгоор нэг цэгийн үйлчилгээнд байрлуулж, үйлчлүүлж байгаа иргэдэд сурталчлан заавар зөвлөгөө өгч энэ онд 86 иргэнд 198 төрлийн үйлчилгээ үзүүлсэн байна.
<b>2.Харилцаа холбооны хүртээмжийг нэмэгдүүлэх, дэд бүтцийн чиглэлээр</b>				
2.1	Сайнтөгрөгийн 4 дүгээр багт үүрэн холбооны сүлжээ тавих	Улсын төсөв	жилдээ	Сайн төгрөгийн 4 дүгээр багт үүрэн холбооны сүлжээ тавих газрын асуудлыг шийдвэрлэсэн сүлжээний ажил ирэх онд хийгдэнэ.
2.2	Киоск машинаас бүх төрлийн лавлагаа гаргах нөхцлөөр хангах (принтертэй болгох)	Улсын төсөв	1-4 дүгээр улиралд	Лавлагааг тухай бүр гаргаж байна.
2.3	Холбооны дэргэд 25 метрийн цамхаг шилжүүлэн барьж, антеннуудыг байршуулан сүлжээний түвшинг сайжруулах, 45 метр цамхагийг барих	Орон нутгийн төсөв 17.2 сая төгрөг	жилдээ	Холбооны дэргэд 25 метрийн цамхаг шилжүүлэн барьж, антеннуудыг байршуулан сүлжээний түвшин сайжруулах, 45 метр цамхагийг барих ажил 09 дүгээр сард эхэлж 90% тай явагдаж байна.
2.4	Нийтийн эзэмшлийн талбайд камержуулалт хийх	Сумын төсөв, орон нутгийн хөгжлийн сан	1-4 дүгээр улиралд	Орон нутгийн хөгжлийн сангийн 85 сая төгрөгийн төсөвт өртгөөр тендер зарласан. 3 компани өрсөлдөж “Баян Сувд эрдэнэ” хязгаарлагдмал хариуцлагатай компани шалгарч 05 дугаар сарын 30-нд гэрээ байгуулж Нийтийн эзэмшлийн гудамж талбайд камержуулсан.
2.5	Сумын төвийн ундны ус түгээх ажлыг цахимжуулах		1 дүгээр улиралд	2023 оны 10 дугаар сараас эхлэн сумын төвд 2 цахим худаг ашиглалтад орж, 2024 оны 03 дугаар сараас эхлэн цахим картаар ус олгож эхэлсэн. Сумын хэмжээнд нийт 809 өрхөөс 345 өрх цахим карт ашиглан ус авч хэрэглэж байна.
<b>3. Иргэдэд цахим сургалт зохион байгуулах чиглэлээр</b>				

3.1	Сургалтын төлөвлөгөөг гаргаж, эзэнжүүлэн хэрэгжилтэд хяналт тавих		03 дугаар сард	Насан туршийн боловсролын багш зорилтод бүлгийн гишүүд, бизнес эрхлэгч, малчид, төрийн албан хаагчид, Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад цахим ур чадварыг нэмэгдүүлэх сургалт зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. Ахмад настан, Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад сургалтыг зохион байгуулсан.
3.2	Сургагч багш бэлтгэх (сургалтад хамруулах)	Орон нутгийн төсөв	02 дугаар сард	Цахим шилжилтийг эрчимжүүлэх зорилтод жилийн хүрээнд сургагч багшаар Насан туршийн боловсролын багш Н.Тунгалаг Өвөрхангай аймагт 1 өдрийн сургалтад хамрагдсан.
3.3	Модуль 1 сургалт-Зорилтот бүлэг (хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настан, иргэд) (танхим, явуул)-ийн сургалт хийх	Байгууллагын төсөв	1 дүгээр улиралд	<p>Зорилтод бүлгийн 10 иргэн, Цэргийн насны 20 залуу, Хөгжлийн бэрхшээлтэй 5 иргэн, 10 ахмад настанд E-Mongolia-гаас гарах үйлчилгээ, лавлаа E баримтаар хэрхэн эрүүл мэндийн даатгал төлөх талаар сургалт хийж мэдээлэл өгсөн.</p> 

				
3.4	Модуль 2 сургалт-Бизнес эрхлэгч (танхим)	Байгууллагын төсөв	2 дугаар улиралд	Сургалтыг бизнес эрхлэгч 6 иргэнд зохион байгуулсан.
3.5	Модуль 3 сургалт-Малчин (явуулын сургалт)	Байгууллагын төсөв	2-3дугаар улиралд	<p>Цахим шилжилтийг эрчимжүүлэх зорилтот жилийн хүрээнд иргэдийн цахим ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор сумандаа зохион байгуулсан Малчдын зөвлөгөөнд Өвөрхангай аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтсээс мэргэжилтнүүдийг урьж оролцуулав. Зөвлөгөөнд нийт 150 орчим малчид оролцож цахим ур чадварын талаар мэдээлэл авсан.</p> 

3.6	Модуль 4 сургалт-Төрийн алба хаагчид (танхим)	Байгууллагын төсөв	1-4дүгээр улиралд	<p>Цахим шилжилтийг эрчимжүүлэх жилийн хүрээнд 32 төрийн албан хаагчид киоск, EMongolia-гаас хэрхэн үйлчилгээ авах талаар мэдээлэл хүргэж, зөвлөгөө өгч ажиллаа.</p> 
3.7	Модуль 5 сургалт-Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад (танхим)		1-4дүгээр улиралд	<p>Цахим шилжилтийг эрчимжүүлэх зорилтот жилийн хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн 38 сурагчид зөвлөгөө өгч, мэдээлэл хүргэж ажилласан.</p> 
<b>4.Зорилтот жилийн сурталчилгаа, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчилан таниулах чиглэлээр</b>				
4.1	Тв контент, подкаст бэлтгэх, сурталчилан	Орон нутгийн төсөв	1-4дүгээр	Зорилтот жилийг цахим орчинд 2 удаагийн

	таниулах		улиралд	контент хийж сурталчилсан.
4.2	Цахим орчинд зорилтот жилийн талаарх мэдээллийг вэб сайт болон иргэдэд түгээх	Орон нутгийн төсөв	1-4дүгээр улиралд	Сумын групп болон албан ёсны веб хуудсанд зорилтод жилийн талаарх мэдээлэл байршуулсан. Мөн багуудын иргэдийн нийтийн хурлаар 331 иргэнд, малчдын зөвлөгөөний хурлаар 150 иргэнд танхимаар мэдээлэл өгсөн. Нэг цэгээр үйлчлүүлэгч иргэдэд киоск машинаар төлбөр төлөх, E-Mongolia-с гарах үйлчилгээг танилцуулж зөвлөгөө өгч ажиллаж байна.
4.3	Тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх		Жилдээ	2022 оноос хойш сумын хэмжээнд 1295 иргэн тоон гарын үсэг авсан. 2024 он гарсаар шинээр 68 иргэнд , хоёр Аж ахуй нэгжид тоон гарын үсэг олгож ажилласан байна. Төр банк болон Хаан банк цахим зээл болон гүйлгээг тоон гарын үсгээр олгож хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлж ажиллаж байна.

ХЯНАСАН:

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Ө.БАТТУЯА

ТАЙЛАН БИЧСЭН:

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ХАЛАМЖ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Б.ЦЭРЭНДУЛАМ